

СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН

ЛУ СИНИЙН ЗОХИОЛООС

ХЯТАДЫН УТГА ЗОХИОЛ ДАХЬ ЧӨТГӨР ШУЛМАС*

Лу Синь

I

Гоминданыхан, Коммунистуудтай хамтран ажиллах бодлогоосоо урван тэрсэлж, харин коммунист намыг устгах бодлого явуулах болсноос хойш Гоминданыхан анхнаасаа коммунистуудыг ашиглан умар зуг довтолж ялалт байгуулсны дараа тэднийг сөнөөх төлөвлөгөөтэй байсан мэтээр зарим хүмүүс ярьдаг. Би үүнийг бодит байдалтай нийцэхгүй гэж үздэг. Гоминданы эрх тушаалтнуудын нилээд хэсэг нь эв хамт намд талтай байсан юм. Үүний нэгэн баримт бол тэр үед тэд хоорондоо өрсөлдөн өөрсдийнхөө охид, хөвгүүдийг Зөвлөлтөд суралцуулахаар илгээж байсан явдал юм. Эцэг эхчүүлд үр хүүхэд нь хамгийн үнэ цэнтэй хүмүүс байдаг болохоор тэд яасан ч үр хүүхдээ хожим устгуулахын төлөө сургууль хийлгэхгүй нь мэдээж. Гэвч гоминданы эрх бүхий зарим хүмүүст алдаатай бодол байсан бололтой. Тэд ХКН бол зөвхөн коммунистуудыг л захирч байх ёстой гэж ойлгож байв. Иймээс тэд эрх тушаал, хөрөнгө чинээгээ ихсэж, бага хатнаа улам олшрох ёстой гэж ойлгож байжээ. Наад зах нь эв хамт намын гишүүн болоогүй байсан цагаас лав дордохгүй гэж бодоцгоосон бололтой.

Бидэнд уламжилж ирсэн нэгэн үлгэр бий. Барагцаалбал хоёр мянган жилийн тэртээ Лю овогт нэгэн хүн байжээ. Тэр ихээхэн буян үйлдэж, тоо тоймгүй хүнд бэрхшээл даван туулж, эцэст нь бурхан болсон гэнэ. Тэгээд эхнэрийнхээ хамт дээд тэнгэрт гарах болсонд эхнэр нь тэнгэрийн оронд очих дургүй байж гэнэ. Учир нь өөрийнхөө амьдарч байсан гэр орон, тэжээж байсан нохой тахиагаа орхиж явахыг тэвчихгүй байжээ. Тэгээд Лю овогт арга буюу дээд тэнгэрт энэхүү учир байдлаа айлтган, орон гэр, нохой, тахиа, эхнэрийнхээ хамт дээд тэнгэрт гаргаж өгөхийг хүссэнд тэнгэр бурхан түүнийг ивээж

хүсэлт ёсоор нь болгосон¹ гэдэг. Тэнгэрт гарах гэдэг бол туйлын их өөрчлөгдөх хэрэг байсан боловч Лю овогтны хувьд ямарч хувьралт гараагүй аанай л бахь байдаг хэвээр байжээ.

Хэрэв эв хамтын нийгэмд эрх тушаал бүхий хүмүүсийн хуучин байдлыг огт өөрчлөхгүй, харин ч улам баян чинээлэг болгох юм бол тэд лавтайяа хүлээн зөвшөөрөх байх. Гэтэл эв хамт ёс нь дээд тэнгэр шиг буулт хийж тохиролцох журмаар ажилладаггүй нь хожмын байдлаас нотлогдоод ирмэгц гоминданчууд даруй тийнхүү сөнөөж устгахаар шийджээ. Үр хүүхэд нь дээд зэргийн үнэтэй боловч тэд өөрсдөө бүр ч үнэтэй хүмүүс болжээ.

Тэгээд газар сайгүй олон тооны залуучууд, коммунистууд, коммунист буюу зүүнийхэн гэж сэжиглэгдэх хүмүүс хийгээд тэдний найз нөхөд нь өөрсдийнхөө хийсэн алдааг өөрсдийнхөө цусаар угаахын зэрэгцээ эрх тушаал бүхий хүмүүсийн үйлдсэн алдааг ч угаалцах болжээ. Учир нь эрх тушаалтны урьд гаргасан алдаа бол дээрх хүмүүст мэхлэгдсэнээс болсон тул заавал тэдний цусаар эрх тушаалтны алдааг угааж цэвэрлэх ёстой гэнэ. Олон тооны хэрэт явдлын нарийн учир ийм болсныг залуус ойлгохгүй байв. Тэд Зөвлөлтөд сургууль төгсгөөд Монголоос тэмээ унаж бөөн баяр хөөр болсоор харьж ирдэг байлаа. Тэр үед гадаадын нэгэн жуулчин тэднийг хараад: Эд нарыг эдүгээ эх оронд нь зөвхөн дүүжлүүрийн шон хүлээж байгааг огтхон ч мэдэхгүй байна хэмээн сэтгэл түгшин ярилцаж байсныг би сайн санаж байна. Үнэхээр ч дүүжлүүрийн шон л хүлээж байлаа. Дүүжлүүрийн шон дээр аваачаад хүзүүнд нь дээс углаад орхивол бас өөр хэрэг. Тэгээд ч хүн болгоныг дүүжлэх юм биш. Энд зарим хүмүүст амь гарах өөр зам байж болох байна. Тэр нь

*Энэ өгүүллийг анх англи хэлээр гардаг «Орчин үеийн хятад» гэдэг сар дутмын сэтгүүлийн нэгэн дугаарт нийтэлжээ. Монгол хэлнээ анх удаа хэвлэгдэж байна.

¹«Нан Чяньбэйдяо» хэмээх эмхэтгэлийн «Гэр бүл бол хятад улсын үндэс» гэдэг өгүүллийн 1 дүгээр эүүлтийг үзнэ үү.

дүүжлүүлж байгаа нөхдийнхөө хөлнөөс бүх чадлаараа чангаа арга юм. Энэ нь сэтгэлийн гүн дэх нүглээ бодит байдлаар наминчилж буй харэг гэнэ. Ингэж нүглээ наминчилж, буруугаа хүлээгчдийн ухаан бодол нь туйлын ариун шударга гэнэ.

2.

Тийнхүү Хятадад нүглээ наминчилж чаддаггүй коммунистууд л алагдах ёстой ялтан болж хувирчээ. Нөгөө талаар тэдгээр нь бусад хүмүүст хязгааргүй их боломжийг бий болгож өгчээ. Тиймэрхүү хүмүүс нь нэг ёсны бараа товар болон хувирч, тэднийг мөнгөөр худалдаж болдог болов. Бас тэгээд зарим хүмүүсийг тэд албан ажилтай ч болгож өглөө. Тухайлбал сургуулиудад гарч байгаа ямар нэгэн хөдөлгөөн, хайр дурлалын маргаан зэргийг таслахад хүртэл цөм коммунист гэдэг нэр өгч орхидог болов. Тэгж нэрлэсэн жинхэнэ ялтанг шийтгэн таслах явдал маш хялбар болов. Хэн нэгэн хүн хэрэв чинээлэг шүлэгчтэй маргахад хүрэх юм бол тэр шүлэгч эцэст нь дүгнэн хэлэхдээ: коммунист нам хөрөнгөтөн ангийг эсэргүүцдэг. Би баян чинээлэг болохоор тэд намайг эсэргүүцэж байна. Тиймээс тэр бол коммунист байж таарна. Тэгээд шүлэгч этгээд «алтан танканд» морилон сууж ялалт хийнэ.

Гэтэл хувьсгалт залуусын цус хувьсгалт утга зохиолыг чийглэн соёлоулжээ. Утга зохиол нь урьд урьдынхаас илүү хувьсгалт агуулга чанартай болов.

Гадаадад сурч ирсэн буюу дотооддоо овоо боловсрол олж авсан засгийн газар дахь зарим сэхээтэн залуус яваа яваандаа бүр догьширч эхлээд хамгийн энгийн аргаар ном зохиолыг хориглож, зохиолчдыг сүрдүүлж байснаа сүүлдээ бүр алан хяддаг болжээ. Энэ дайралтанд эүүнийхний таван залуу зохиолчид хэлмэгджээ.² Гэтэл энэ хэрэг явдлын талаар нийтэд албан ёсоор огт зарлаагүй өнгөрөв. Тэд хэрэг үйлдэж болно. Гэхдээ хэлж зарлаж болдоггүйг сайн мэддэг байжээ. Энэ талаар өтгөсийн хэлсэн үг ч бий. «Морин дэл дээрээс тэнгэрийн доорхийг эзэлж болно. Харин тэнгэрийн доорхийг морин дэл дээрээс захирч болохгүй».³ Тийнхүү хувьсгалт утга зохиолыг устгахын тулд эргээд утга зохиолын зэвсгийг хэрэглэх шаардлагатай болжээ. Тийм зэвсэг болж хувирсан зүйл гэвэл, «үндэстний утга зохиол» гэдгийг дурдаж болно. Тэд дэлхийн олон арьстны нүүрний өнгийг судлаад өнгө

нэгтэй арьстнууд эрхбиш нэгдмэл үйл явдалтай байх ёстой гэж тогтоосон байна. Тухайлбал шар арьстны пролетариуд нь шар арьст хөрөнгөтнүүдтэй тэмцэлдэхгүй харин цагаан арьстны пролетариудтай тэмцэлдэх ёстой гэнэ.

Тэд бас Чингэс хааныг санаж олоод түүгээр үлгэр жишээ болгож Чингэсийн ач Бат хаан, хэрхэн шар арьстан үндэстнүүдийг дагуулан Оросод түрэмгийлэн орж, тэдний соёлыг сүйтгэн бусниулсан хийгээд язгууртан ба энгийн ард иргэдийг хэрхэн боолчилж байсан тухай дүрслэн бичдэг болов.⁴

Гэтэл хятад хүн монголын хааныг дагалдан байлдсан явдал бол үнэн хэрэг дээрээ хятад үндэстний бахархал гэж тооцогдохгүй билээ. Гэвч тэд Оросыг сөнөөхийн тулд ингэхгүйгээр болохгүй байжээ. Учир нь манай эрх тушаалтнууд эртний Орос гэдэг нь одоогийн Зөвлөлт болохыг нэгэнт мэдэж авсан байв. Зөвлөлтийн үзэл нь тэднийг эрх тушаал, хөрөнгө чинээ, бага хатныг нь хэрхэвч нэмэгдүүлэхгүй гэдгийг эцэст нь тэд ойлгосон юм байжээ.

Харин одоогийн Бат хаан гэгч нарийндаа чухам хэн болж байна?

1931 оны есдүгээр сард Япон, Хятадын зүүн хойд гурван мужийг түрэмгийлэн эзлэв. Энэ чинь ёстой л хятад хүн бусдыг дагалдан Зөвлөлтийг хөнөөн устгахын удиртгал хөгжмийн эгшиг болсон юм.

Үндсэрхэг үзэлт зохиолчдын сэтгэл ханамжтай боллоо.

Харин жирийн ард иргэд одоогийн алдагдаж байгаа зүүн гурван муж нь Зөвлөлтийг хөнөөн устгахаас ч чухал тулгамдсан асуудал болоод байна гэдгийг ойлгоод японы эсрэг эрслэн босоцгоосон юм. Тэгтэл үндсэрхэг үзэлт зохиолчид арга буюу эмээлийн хазайсан зүг рүү дарахад хүрч тэр хэргийн төлөө чарлан гуаглах болов.

Халуун сэтгэл бүхий үй олон залуус Наньжин хот руу очиж цэрэг дайчлан тэмцэх хүсэлт тавьдаг болов. Энэ үйлсийнхээ төлөө тэд багагүй гашуун зовлон амсаж, хүнд сорилтыг гэтлэн давахад хүрэв. Галт тэргэнд тэднийг суулгахгүй болохоор хөдөө хээр хэд хоногийг өнгөрүүлдэг ч байв. Тэд арай ядан Наньжин руу явах унаанд залгадаг. Харин ихэнх хүмүүс явган аялахаас өөр аргагүй байлаа. Чуу чамай Наньжин хотод хүрч очиход тэдний өөдөөс тусгай сургууль хийсэн «ард

²«Нан Чяньбэй дяо» хэмээх эмхэтгэлийн «Мартагдсан дурсгалын төлөө» 120 дугаар тал.

³Энэ нь Хан улсын Лу Зягийн үг. «Ши Зи» хэмээх түүхийн тэмдэглэл. 97 дугаар боть, Лу Зягийн шаштирт.

⁴«Энэ хэсэг болон дараагийн 3 хэсэг өгүүлбэрийг «Эр чинь Зе», «үндэстний утга зохиолын үүрэг ба хуеь заяа» хэмээх эүүлтээс үз.

олон» гэгч нэртэй отряд бороохой шийдэм, суран ташуур, гар буу барьсаар тосч очоод нүүр нүдгүй балбаж нүдэж, тэнд хүрэлцэн ирэгсэдийн нүүр царай бие махбодь нь энд тэндгүй овон товон хавдаж пиндийгээд уруу царайлан урам зориггүй гэртээ буцахад хүрнэ. Зарим нэг нь бүр ор сураггүй алга болж орхидог байв. Зарим нь усанд живж үхсэн. байдаг. Гэтэл сонинд тэднийг өөрсдөө усанд унаж үхсэн мэтээр мэдээлдэг юм байна.

Энэ үед үндсэрхэг үзэлт зохиолчдын гуаглаж хашгирах нь эцэс болж, сүүдэр нь ч харагдахаа болив. Тэд хүмүүсийг нутаглуулах үүргээ нэгэнт гүйцэтгэсэн байв.

Энэ нь Шанхай хотын оршуулгын ёслолтой адил байсан бөгөөд гарахдаа дуу хөгжмийн замбараагүй аялгуу мэт уйлах чимээ сонсогдож байв. Энэ оршуулгын зорилго гэвэл гаслан зовлонгоо булшлах, дахин тэр тухай хэзээ ч дурсаж санахгүй байхад л оршиж байжээ. Энэ зорилгоо биелүүлэнгүүт цөм тал тал тийшээ тарцгаан, дахиад ямар ч эгнээ бүрдэхгүй болов.

3.

Гэвч хувьсгалт утга зохиол ганхаж гуйваагүй бас л хөгжсөөр, уншигчдын итгэл улам нэмэгдсээр байв. Гэтэл өөр нэг талаас «гурав дахь хүмүүс» гэгч гарч ирэв. Тэд зүүн жигүүрийнхэн биш нь маргаангүй хэрэг. Гэвч баруун жигүүрийнх ч биш бөгөөд зүүн барууны гаднах чөлөөт хүмүүс бөлгөө. Тэднийхээр бол утга зохиол нь үүрд мөнх байдаг. Улс төрийн үзэгдэл бол түр зуурын зүйл гэнэ. Тиймээс утга зохиолыг улс төртэй холбож болохгүй, нэг л холбочихвол түүний үүрдийн чанар алдагдаад хожим хятадад аугаа их зохиол бүтээл гарахгүйд хүрнэ гэнэ. Гэтэл утга зохиолд үнэнч гэгдэх «гурав дахь хүмүүс» бологчид ч гэсэн аугаа их бүтээлийг мөн л туурвихгүй байна. Яагаад гэвэл утга зохиолыг ойлгодоггүй зүүн жигүүрийн шүүмжлэгчдийн буруу номлолд автагдсан хүмүүс тэдний сайн бүтээлийг хурц, буруу шүүмжилж байгаагаас болж, дорвитой бүтээл туурвиж чадахгүйд хүрчээ. Тиймээс зүүн жигүүрийн шүүмжлэгчид бол хятадын утга зохиолын яргачид ажээ.

Харин тэд засгийн газраас хориглосон ном зохиол, алж хядагдсан зохиолчдын тухай огт юу ч ярихгүй байна. Яагаад гэвэл улс төрд хамаарах учир тэр тухай ярих л юм бол тэдний бүтээлийн үүрд мөнх чанар нь алдагдахад хүрнэ. Тэгэхдээ харин ном зохиолыг хориглон

зогсоосон «Хятадын утга зохиолын яргачид»-ыг алж хядсан этгээд нь эргээд «гурав дахь хүмүүс»-ийн үүрдийн зохиол, аугаа их бүтээлийн хамгаалагчид болчихоод байгаа юм.

Ингэж дөнгөж амьсгаатай атлаа нэг хэвийн хуурамч дүр үзүүлсэн гаслан тоочих нь хэдийгээр бас нэг ёсны зэвсэг боловч түүний хүч хариугүй бага болох нь мэдээж юм. Хувьсгалт утга зохиол түүнд хэрхэвч ялагдахгүй байх.

«Үндсэрхэг утга зохиол» нэгэнт өөрөө сөнөчихөөд байна. «Гурав дахь утга зохиол» нь бас хөл дээрээ зогсож чадахгүй байна. Ийм үед бас дахиад л жинхэнэ зэвсгийг хэрэглэхгүй бол болохгүй болжээ.

1933 оны арван нэгдүгээр сард Шанхай дахь «И Ин» хэмээх кино үйлдвэрийг хэсэг хүмүүс гэнэт дайран орж бүх юмыг нь эвдэн бусниулав. Тэд нь маш зохион байгуулалттай ажиллаж байв. Шүгэл дуугарахад хөдөлж, шүглийн дуугаар зогсож, бас шүглийн дуугаар тарцгаадаг байв. Тухайн үедээ бас ухуулах хуудас үлдээж түүнд: «Тус үйлдвэр нь Коммунист Намд ашиглагдсан учир дайрсан юм» гэж бичжээ.

Энэ мэт дайралтанд зөвхөн кино үйлдвэр ч өртөөд зогсоогүй номын дэлгүүр лүү ч чиглэдэг байв. Хэрэг явдал хүндрээд ирвэл хэсэг бүлэг хүмүүс дайран орж бүх зүйлийг эвдэж хэмхчих, хөнгөн байвал хаанаас ч юм бүү мэд чулуу шидээд 200 янчааны үнэтэй цонхны шилийг хагалж хаядаг.⁶ Учир шалтгаан нь гэвэл тэр дэлгүүр мөн л Коммунист Намд ашиглагдсан гэнэ. Номын дэлгүүрийн өндөр үнэ бүхий цонхны шил нь аюулд учирсанд пүүсний эзэн ихэд харамсаж байв. Хэд хоногийн дараа «зохиолч» ирж өөрийнхөө «сайн бүтээл»-ийг түүнд худалдав. Уул зохиолыг хэвлээд унших хүн олдохгүй гэдгийг пүүсний эзэн мэдэх боловч авах л хэрэгтэй болов. Учир нь цонхны нэг дөрвөлжин шилний үнэтэй тэнцэхийн дээр хоёр дахь чулуу ч нисч ирэхгүй, дахиад л цонх хаалга засан сэлбэх ажил ч гарахгүй болно.

4.

Номын дэлгүүрт даралт үзүүлэх нь үнэхээр хамгийн сайн стратеги арга болж хувирав. Тэгэхдээ хэдхэн чулуу нисгэх нь төдий л хангалттай биш байсан бололтой. Төвийн суртал ухуулгын комисс нилээд их номыг шалгаж үзээд хоригложээ. Бүгд гүйлгээ сайтай 149 төрлийн хэвлэлд бараг бүх ном

⁵«Нян цянь бэй дяо» хэмээх эмхтгэл. «Гурав дахь хүмүүс»-ийн 123 дугаар талд үз.

⁶«Хуай фэн юе тан». «Хоу Зи» хэмээхийн 123 дугаар талд үзнэ үү.

хамрагджээ. Хятадын зүүн жигүүрийн
зохиолчдын бүтээлийн ихэнхийг хааж
орчуулгын ном зохиолыг ч хориглох бо-

⁵«Нян цянь бэй дяо» хэмээх эмхтгэл. «Гурав дахь хүмүүс»-ийн 123 дугаар талд үз.

⁶«Хуай фэн юе тан». «Хоу Зи» хэмээхийн 123 дугаар талд үзнэ үү.

лов. Түүнээс зарим зохиолчийг дурдвал: Горький, Луначарский Федин, Фадеев, Серафимович, Эптон Синклер, Митерлинск, Шолохов, Стриндберг нар цөм хамрагджээ.⁷

Энэ нь хэвлэлийн газруудыг хүнд байдалд оруулав. Тэдний зарим нь дээрх номуудыг тэр дор нь хурааж шатаалгав. Зарим нь нөхөн сэргээх санаатай албаны газар зөвлөхөөр очоод нэг заримыг нь авч хоцрох болов. Тийнхүү хойшид хэвлэлийн газарт тохиолдох бэрхшээлийг хөнгөлөх үүднээс албан хаагчид, хэвлэлийн газрын хооронд зөвлөлгөө хийв. Уул зөвлөлгөөнд «гурав дахь хүмүүс» гэгдэх хэдэн хүн сэтгүүлийн редакторын мэргэшлээр оролцохдоо «сайн бүтээл» хийгээд хэвлэлийн газрын хөрөнгө мөнгийг хамгаалахын тулд Японд хэрэгжиж байгаа аргыг авч хэрэглэх нь эүйтэй гэдэг санал гаргажээ. Тэр нь ном зохиолыг хэвлэхийг зөвшөөрсөн тамга дарахаас өмнө эх бичгийг сайтар шалгаж үзсэний үндсэн дээр хасаж, засах зэрэг өөрчлөлт хийсэн байх хэрэгтэй. Тэгэхгүй юм бол зүүн жигүүрийн зохиолчдын бүтээлд бусад хүмүүсийг холбогдуулж хориглох явдал ч гарч болно. Нөгөө талаар зохиол нэгэнт нийтлэгдсэний дараа уг зохиолыг хориглох нь хэвлэлийн газрын эзэд алдагдалд орно гэжээ. Энэ санал олон талын хүмүүст таашаагджээ. Энэ нь хэдийгээр Бат хааны хуучин арга биш боловч дор нь хүлээн авсан байна. Тэгээд бас төдхөн хэрэгжүүлж эхлэв. Энэ оны долдугаар сард Шанхайд ном сэтгүүлийг шалгах газартай болов.⁸ Олон «зохиолч»-дын ажилгүйдэх асуудал үгүй болов. Бас зарим нь буруугаа хулээн гэмшигч хувьсгалт зохиолчид хийгээд утга зохиолыг улс төртэй холбохыг эсэргүүцдэг «гуравдахь хүмүүс» цөмөөрөө байцаагч түшмэлийн сандал дээр сууцгаажээ. Тэд утга зохиолын байдлыг сайн мэддэг, тэдний тархи толгой нь албаны хүнд сурталт түшмэл шиг тэнэг биш өчүүхэн төдий ёж үг, эсэргүү утгатай ганц өгүүлбэрийн учир агуулгыг харьцангуйгаар сайн ойлгодог. Бас тэгээд утга зохиолын үгээр засч өөрчлөнө. Тэдэнд ямарч гэсэн бүтээл туурвихаас зовлон

багатай болов. Тэгээд ч амжилтын хувьд маш сайн сурагтай.

Гэвч тэд Японоос үлгэр авсан нь буруутжээ. Японд ангийн тэмцлийн тухай яриулахгүй боловч дэлхийд ангийн тэмцэл байдаггүй гэж хэлдэггүй. Гэтэл Хятадад бол дэлхийд ангийн тэмцэл гэж хэрэг дээрээ байдаггүй. Маркс л санаанаасаа зохион гаргажээ. Үүнийг яриулахгүй нь үнэнийг хамгаалахын төлөө юм гэдэг байна.

Японд ном, сэтгүүлийг бас л хааж хориглож хасч дарж байдаг боловч хассан газраа зай үлдээж онгорхой орхидог. Тиймээс уншигчид харангуут энүүхэн хэсгийг хасчээ гэдгийг ойлгодог. Гэтэл хятадад хасаад онгорхой зай үлдээхийг зөвшөөрдөггүй, хооронд нь заавал холбосон байдаг. Тиймээс уншигчдын өмнө хаанаас ч хасаагүй бүхэл бүтэн өгүүлбэр мэт ойлгогддог. Энэ нь зөвхөн зохиолч л утга нь ойлгогдохгүй тэнэг үг хэлж буй мэт болдог. Ийм байдлаас болоод хятадын уншигчдад Фриче, Луначарский нар тэнэг үг хэлж байгаа юм шиг болж байна. Ингэснээр хэвлэлийн газрын эздийн хөрөнгө нь баттай болов. Гэтэл «гуравдахь хүмүүс»-ийн туг ч харагдахаа болив. Тэд далдуураа мөн л дүүжлэгдсэн мэргэжил нэгтийхээ хөлнөөс байдаг чадлаараа чангаасаар л байна. Тэдний жинхэнэ дүрийг дуослэн бичдэг нэг ч тогтмол хэвлэл үгүй байна. Юу гэвэл тэд халхлагдсан бийрнийхээ үзүүрээр зэрлэг аллага үйлдэх эрхийг гартаа авчээ.

Уншигчдын хувьд гэвэл тогтмол хэвлэл идэвхгүй болжээ. Бүтээл нь доройтож байна. Харин гадаадад уулаас нэртэй бөгөөд давшилттай зохиолчийн ихэнх нь энэ жил гэнэт согогтой этгээд болж хувирсан мэт ойлголт тэдэнд байх болов. Чухамдаа утга зохиолчдын хоорондох чиг шугам нь улам тодорч ирэв. Хааж халхлах явдал удаан үргэлжлэж чадахгүй болжээ. Цуст тэмцэл дахиад босч ирэх болно.

«Лу Синий бүрэн зохиолын эмхэтгэл» VI боть. 119-125-р тал. Хятад хэлнээс орчуулсан Ц. Хандсүрэн

⁷Гоминдан Намын Төв Хорооны суртал ухуулах комиссоос хориглосон 149 төрлийн номны тухай «Че Зетин за вэнь эр Зи», «Хоу Зи»-д үзнэ уу. Луначарский «Сан сянь Зи» «Тун син»-ий зүүлт 12-ыг үз. Федин, зөвлөлтийн зохиолч. Синклерын талаар «Сан сянь Зи». «зүй янь Жунди мэнлун» зүүлт. 13 Митерлинск (1862—1949) Персийн жүжгийн зохиолч Стриндберг (1849—1912) Шведийн зохиолч бөгөөд мөн жүжгийн зохиолч.

⁸Гоминдан НТХ-ны ном, сэтгүүлийг шалган байцаах комиссыг хэлж буй.